

Захирлын 2026 оны 05 дугаар  
сарын 18-ны өдрийн 4/28 дугаар  
тушаалын ... дугаар хавсралт



## МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ХАРЬЯА ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН АХЛАХ СУРГУУЛЬД 2026-2027 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

1. Монгол улсын их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургуулийн төрөлжсөн сургалттай 10 дугаар ангид нийслэл хот болон хөдөө орон нутгаас 2026-2027 оны хичээлийн жилд суралцагч элсүүлэхэд энэхүү журмыг баримтална.

2. Ахлах сургуульд элсэхээр бүртгүүлэгч, элсэгч болон элсэлтийн комиссын үйл ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

3. Ахлах сургуульд элсэхээр хүсэлт гаргасан суралцагчийг “бүртгүүлэгч”, зохих болзол хангаж элсэлтийн хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчийг “элсэгч”, элсэлтийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулахаар томилогдсон комиссыг “элсэлтийн комисс”, “элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад оролцох ажилтныг “комиссын гишүүн” гэнэ.

4. Ахлах сургуульд суралцагч элсүүлэх ажлыг захирлын тушаалаар томилсон комисс зохион байгуулна.

5. Бүртгүүлэгч бүртгүүлэхээс өмнө энэхүү журамтай танилцах үүрэгтэй.

6. Энэхүү журам болон нэмэлт мэдээллийг <http://highschool.num.edu.mn> сайт, “МУИС-ийн Ахлах сургууль” нүүр номын хуудсанд тус тус байрлуулна.

7. Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал захирлын тушаалаар байгуулсан элсэлтийн комисс шийдвэрлэнэ.

8. Элсэлтийн шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сэдэв боловсруулах, шалгалтын хугацаа ба үнэлгээний шалгуур тогтоох, нууцлал хадгалах зэрэг асуудлыг элсэлтийн комиссын дарга, нарийн бичгийн дарга, комиссын гишүүд хариуцна.

9. Тус сургуульд элсэхийг хүссэн, 9 дүгээр анги төгсөж байгаа суралцагчдыг бүртгэнэ.

10. Сургуулийн зөвлөлийн тогтоолоор баталсны дагуу элсэхээр бүртгүүлэгчдээс бүртгэлийн хураамж 30,000 (гучин мянга) төгрөг авна.

11. Нийт бүртгүүлэгчдээс математикийн шалгалт авна. Мөн бүртгүүлэгчийн анги сонголтоос хамаарч физик, хими, биологийн шалгалт нэмж авна. Онооны жагсаалтыг математик, математик-физик, математик-хими, математик-биологи гэж гарган, гүнзгийрүүлэн судлах чиглэлийн бүлэг тус бүрээр зохих хяналтын тоонд багтааж элсүүлнэ.

12. Улс, аймаг, нийслэл, дүүргийн төрөлжсөн олимпиадын математик, физик, хими, биологийн хичээлийн төрөлд оролцож медальт байр эзэлсэн суралцагчдыг хяналтын тоонд багтаан шалгалтгүй (урилгаар) элсүүлнэ.

13. Урилгаар элсэгчдийн сургалтын төлбөрийг дараах байдлаар хөнгөлнө.  
Үүнд:

- Улсын төрөлжсөн олимпиадын математик, физик, хими, биологийн хичээлийн төрөлд эхний 3 байр эзэлсэн суралцагчдын эхний жилийн сургалтын төлбөрийг 100 хувь,

- Аймаг, нийслэлийн төрөлжсөн олимпиадын математик, физик, хими, биологийн хичээлийн төрөлд алтан медаль 30 хувь, мөнгөн медаль 25 хувь, хүрэл медаль 20 хувь,

14. Урилгаар элсэн суралцах элсэгчид элсэлтийн шалгалтаас өмнө 06 дугаар сарын 06-ны дотор сургалтын төлбөрийг 100 хувийг төлж элсэлтийг баталгаажуулна.

15. Элсэлтийн шалгалтад тэнцэж, хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчдийг заасан хугацаанд сургалтын төлбөрийг 100 хувь 9,500,000 (есөн сая таван зуун мянга) төгрөгийг сургуулийн ХААН банк дахь 5041126984 дугаар дансанд тушаасан баримтаар бүртгэж, ангийн суудал, элсэх эрхээ баталгаажуулна.

16. Зарласан хугацаанд ирж бүртгүүлээгүй элсэгчийг тус сургуульд элсэхээс татгалзсан гэж үзэн, дараа өдрийн 10:00 цагаар тасалбар болгоно.

17. Зарласан хугацаанаас хойш урилгаар элсэх хүсэлт гаргасан бүртгүүлэгчийн хувьд тухайн ангийн дүүргэлт хяналтын тоонд хүрээгүй байвал журмын 11 дэх заалт үйлчилнэ.

18. Баталгаажсан орон тоог хүчингүй болгож элсэлтийн тоонд өөрчлөлт оруулсан тохиолдолд нийт сургалтын төлбөрийн 5 хувийн суутгалыг сургуульд төлнө.

19. 2026-2027 оны хичээлийн жилд элсэх эрхээ баталгаажуулсан элсэгчид 2026 оны 08 дугаар сарын 24-ний өдрөөс 28-ны өдрийн хооронд дараах материалыг бүрдүүлж, бүртгүүлнэ. Үүнд:

- Төрсний гэрчилгээний хуулбар
- Суурь боловсролын гэрчилгээ
- Хувийн хэрэг /шилжүүлсэн байх/

20. Тухайн элсэгчийн сонгосон бүлгээс өөр бүлэгт шилжүүлэн элсүүлэхгүй ба элсэлтийн эрхийн бичгийг бусдад шилжүүлэхийг хориглоно.